



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 12 өдөр

Дугаар A/206

Батширээт сум

**Асран хамгаалагч, харгалзан дэмжигч
тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дах заалт, 67 дугаар зүйлийн 67.1.1 дэх заалт, 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалт, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аливаа овогтой Үер нь өөрийн хүүхдүүд болох Болдхуягийн Аззаяа, Шинэхүүгийн Энхжин нарыг хүүхдүүдээ үл хайхран анхаарал халамж тавихаа больсон учир Б.Аззаяа, Ш.Энхжин нарын асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр А.Үерийн ээж Д.Алимааг тогтоосугай.
2. Холбогдох бичиг баримтын бүрдэл, хувийн хэргийг хөтлөн ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан (Д.Нямсүрэн)-д даалгасугай.
3. Гэр бүлийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийг баримталж Б.Аззаяа, Ш.Энхжин нарыг асран хамгаалж, харгалзан дэмжихийг (Д.Алимаа)-д даалгасугай.
4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Норовлин багийн засаг дарга (Б.Бадамгарав), Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан (Д.Нямсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232501407